



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

“Азиа Пасифик Пропертис” ХК-ийн үнэт цаасны
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.2, 34.1.7, Компанийн тухай хуулийн 20, 31.3 дугаар зүйл, “Азиа Пасифик Пропертис” ХК-ийн 2012 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 02, 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Азиа Пасифик Пропертис” ХК-ийн нийт гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 175,265 ширхэг хувьцааг нэгдэж буй “Рурал Девелопмент Корпорейшн” ХХК-ийн хөрөнгөд оногдох нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 177,505 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоолын 1-т заасан “Азиа Пасифик Пропертис” ХК-ийн нэмж гаргаж буй 177,505 ширхэг энгийн хувьцааг компанийн халаасны хувьцаанд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Азиа Пасифик Пропертис” ХК /Э.Одбаяр/-д үүрэг болгосугай:

1/ “Азиа Пасифик Пропертис” ХК-д “Рурал Девелопмент Корпорейшн” ХХК-ийг нэгтгэсэнтэй холбогдуулан хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөн байгуулах, “Рурал Девелопмент Корпорейшн” ХХК-ийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрхийг “Азиа Пасифик Пропертис” ХК-д шилжүүлэх, холбогдох хууль, тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх;

2/ 2012 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд гарсан өөрчлөлтийг тусгах;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Монголын компанийн засаглалын кодекс болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах.

4. Энэ тогтоолын 1, 2, 3-т заасан ажиллагааг хэрэгжүүлж дууссаны дараа “Азиа Пасифик Пропертис” ХК-ийн албан хүсэлтэд үндэслэн үнэт цаасны арилжааг сэргээхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т зөвшөөрсүгэй.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН